



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/27

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалт, Засгийн газрын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/49 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын аварга малчин, аймгийн хошой аварга, аварга малчин, хадланч, тариаланчийн шагнал урамшуулал болон хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 11,196,500 (арван нэгэн сая нэг зуун ерэн зургаан мянга таван зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны  
08 дугаар сарын 10 -ны өдрийн 167 дугаар  
захирамжийн хавсралт



### ХӨРӨНГИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Чихэр	117	25,000	2,925,000
2	Календарь	117	5500	643,500
3	Хадаг	234	8,000	1,872,000
4	Үнэмлэх	112	3,000	336,000
5	Домбо	5	180,000	900,000
6	Дуран	5	170,000	850,000
7	Тээврийн зардал		1,000,000	1,000,000
8	Зураг угаалгах	112	10000	1,120,000
9	Бусад зардал			1,550,000
Нийт дүн				11,196,500

\_ оОо \_

